



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2021 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 85

Улаанбаатар хот

Үл хөдлөх хөрөнгө төрийн өмчид бүртгэх  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1, 4.1.2, 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сүхбаатар дүүргийн 6 дугаар хороо, Бага тойруу /14200/ НҮБ-ын гудамж 37 дугаар байранд байрлах хавсралтад заасан нийт 532,645,287.00 (таван зуун гучин хоёр сая зургаан зуун дөчин таван мянга хоёр зуун наян долоон) төгрөгийн үнэлгээ бүхий 298.27 м.кв бүхий 6 орон сууц, 2 авто зогсоолыг төрийн өмчид хүлээн авч Монгол Улсын Их Сургуульд эзэмшүүлэн, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Батбаатар, Монгол Улсын Их Сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Очирхуяг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, үндсэн хөрөнгөд бүртгэх;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Энэ шийдвэрийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлэн мэдэгдэж арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-г үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001304

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2020 оны 04 дүгээр сарын 22-ний өдрийн  
... дугаар тогтоолын хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ҮНДСЭН  
ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

| Д/д | Үл хөдлөх хөрөнгийн нэр,<br>байршил                                                                                 | Хэмжих<br>нэгж<br>/м.кв/ | Өрөөний<br>тоо | Нэгж үнэ /төгрөг/ | Нийт үнэ /төгрөг/                                                                                      |
|-----|---------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------|----------------|-------------------|--------------------------------------------------------------------------------------------------------|
| 1   | Сүхбаатар дүүргийн 6 дугаар<br>хороо, Бага тойруу /14200/ НҮБ-<br>ын гудамж 37 дугаар байр 92<br>тоот               | 45.74                    | 2              | 1,598,100.00      | 73,097,094.00                                                                                          |
| 2   | Сүхбаатар дүүргийн 6 дугаар<br>хороо, Бага тойруу /14200/ НҮБ-<br>ын гудамж 37 дугаар байр 93<br>тоот               | 53.91                    | 2              | 1,598,100.00      | 86,153,571.00                                                                                          |
| 3   | Сүхбаатар дүүргийн 6 дугаар<br>хороо, Бага тойруу /14200/ НҮБ-<br>ын гудамж 37 дугаар байр 94<br>тоот               | 55.05                    | 2              | 1,598,100.00      | 87,975,405.00                                                                                          |
| 4   | Сүхбаатар дүүргийн 6 дугаар<br>хороо, Бага тойруу /14200/ НҮБ-<br>ын гудамж 37 дугаар байр 95<br>тоот               | 45.66                    | 2              | 1,598,100.00      | 72,969,246.00                                                                                          |
| 5   | Сүхбаатар дүүргийн 6 дугаар<br>хороо, Бага тойруу /14200/ НҮБ-<br>ын гудамж 37 дугаар байр 96<br>тоот               | 30.53                    | 1              | 1,598,100.00      | 48,789,993.00                                                                                          |
| 6   | Сүхбаатар дүүргийн 6 дугаар<br>хороо, Бага тойруу /14200/ НҮБ-<br>ын гудамж 37 дугаар байр 97<br>тоот               | 67.38                    | 3              | 1,598,100.00      | 107,679,978.00                                                                                         |
| 7   | Авто зогсоол 04 тоот /Сүхбаатар<br>дүүргийн 6 дугаар хороо, Бага<br>тойруу /14200/ НҮБ-ын гудамж<br>37 дугаар байр/ | 18                       |                | 1,555,000         | 27,990,000.00                                                                                          |
| 8   | Авто зогсоол 07 тоот /Сүхбаатар<br>дүүргийн 6 дугаар хороо, Бага<br>тойруу /14200/ НҮБ-ын гудамж<br>37 дугаар байр/ | 18                       |                | 1,555,000         | 27,990,000.00                                                                                          |
|     |                                                                                                                     | <b>334.27</b>            |                |                   | <b>532,645,287.00</b>                                                                                  |
|     | <b>Нийт дүн</b>                                                                                                     |                          |                |                   | <b>(таван зуун гучин<br/>хоёр сая зургаан<br/>зуун дөчин таван<br/>мянга хоёр зуун<br/>наян долоо)</b> |